# “ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар сарын 21-ний өдөр № 20/33 Улаанбаатар хот

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээс чөлөөлөх тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” )-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн Үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.10 дахь хэсэг, Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 10 дугаар сарын 21-ний өдрийн 01 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 10 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Чинбат овогтой Номин нь 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн байх тул уг хүсэлтийг хүлээн авч, энэхүү тогтоол гарсан өдрөөр тус гишүүний бүрэн эрхийг зогсоож, Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээс чөлөөлөх асуудлыг Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр тогтоосугай.

2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн тухай мэдээллийг холбогдох журамд заасны дагуу олон нийтэд мэдээлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар-д үүрэг болгосугай.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

**ТУЗ-ИЙН ДАРГА**

**/ЦОДМАА/**